



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 19-ны өдөр

Дугаар 4/02

Булган

“Сувилагч нарын мэргэжлийн мэдлэг,
ур чадварыг дээшлүүлэх нь” сэдэвт
сургалт зохион байгуулах тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалтууд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/30 дугаар тушаал (Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, заавар батлах тухай), 2021 оны А/329 дүгээр тушаал (Эмнэлэгт суурилсан тандалт хийх, журам, зураглал, лабораторийн хуваарь батлах тухай), 2021 оны А/814 дүгээр тушаал (Журам шинэчлэн батлах тухай), 2022 оны А/36 дугаар тушаал (Түр заавар шинэчлэн батлах тухай), 2021 оны 05 дугаар албан даалгавар (Коронавируст халдварын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай)-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сувилагч нарын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, Сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.


2. Удирдамжийг баримтлан сургалтыг онол, дадлага, хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулан, сургалтын үр дүнг тооцож, Эрүүл мэндийн байгууллагуудыг эргэн мэдээллээр ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (Д.Нарантуяа), Сувилахуй, яаралтай тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Д.Отгонсүрэн)/ нарт үүрэг болгосугай.

3. Сургалтын үйл ажиллагаанд шаардагдах зардал 870000.00 (Найман зуун далан мянга) төгрөгийг зохих эх үүсвэрээс зарцуулахыг нягтлан бодогч (Б.Энхтуяа)-д зөвшөөрч, Санхүүгийн анхан шатны баримтыг холбогдох журмаар бүрдүүлэн ажиллахыг нярав (Э.Хосбаяр) нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, санхүүгийн ил тод байдал, “Шилэн дансны тухай” хуулийг баримтлан ажиллахыг Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, салбарын санхүүгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн (П.Мягмарсүрэн), Төрийн албан хаагчдын сургалтын үр дүнг ЭМБ-уудын жилийн эцсийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэнд тооцохыг Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал, байгууллагын дотоод аудит хариуцсан мэргэжилтэн (Б.Батцэцэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  С.НАРАНТУЯА

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
01 дугаар сарын 19 ны өдрийн 0102 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



“СУВИЛАГЧ НАРЫН МЭРГЭЖЛИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Зорилго: Эрүүл мэндийн байгууллагуудын ахлах болон дархлаажуулалтын сувилагч нарын мэргэжлийн мэдлэг, багаар ажиллах ур чадварыг дээшлүүлэхэд оршино.

Зорилт:

1. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн дүгнэлтийг хэлэлцүүлэх
2. Сувилагч нарт сэдэвчилсэн сургалтыг лекц, дадлага хэлбэрээр зохион байгуулах
3. Сувилахуйн чиглэлээр 2022 онд хийх ажлыг төлөвлөх

Зохион байгуулагч:

Эмнэлгийн тусламжийн болон Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс

Оролцогч:

Сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч, дархлаажуулалтын сувилагч нар

Хугацаа:

2021 оны 01 сарын 21-ны өдөр

Хаана: Эрүүл мэндийн газрын сургалтын танхим, Цоожэд өрхийн Эрүүл мэндийн төвийн сургалтын танхим

Сургалтын үр дүн:

1. Сувилагч нар туберкулины сорил тавих арга зүй, утлага хийх аргачлал, цэвэр хүчилтөрөгчийг баллоноор өгөх, тариурын шахуургаар тарилга хийх аргачлалыг бүрэн, зөв сурсан байна.
2. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг нэгтгэн 2020, 2021 оны харьцуулсан үнэлгээг гаргаж, ЭМБ-уудад зөвлөмж хүргүүлнэ.
3. Сувилахуйн тусламж үйлчилгээний 2022 онын төлөвлөгөөг боловсруулан батлуулна.
4. “Коронавирусын халдварын үед хэрэгжүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ”, “Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг тандах” талаарх мэдлэг дээшилнэ.
5. БНСУ-ын Ионсей их сургуулийн судлаач, сувилахуйн докторант Д.Дуламсүрэнтэй цахимаар холбогдож, шинэ мэдээлэл авна.

**“АХЛАХ СУВИЛАГЧ НАРЫН МАНЛАЙЛЛЫН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ”
СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ХӨТӨЛБӨР**


№	Цаг	Хичээлийн сэдэв	Хариуцах мэргэжилтэн
Сургалт Эрүүл мэндийн газрын сургалтын танхимд болно. Ахлах сувилагч нар оролцоно.			
1	09:20-09:30	Сургалтын нээлт	ЭМГ-ын дарга С.Нарантуяа
2	09:30-10:30	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал	ЭМГ-ын мэргэжилтэн Д.Отгонсүрэн /СУ-ны магистр, Зөвлөх зэрэгтэй/
3	10:30-11:15	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх тандалт, авах арга хэмжээ	ЭМГ-ын мэргэжилтэн Г.Байгалмаа
Цайны завсарлага			
4	11:30-12:00	Тархалтын түвшингийн үнэлгээ хийх	ЭМГ-ын мэргэжилтэн С.Ариунаа
5	12:00-12:30	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал	ЭМГ-ын мэргэжилтэн О.Оюундарь
6	12:30-13:00	Хүчилтөрөгч эмчилгээг баллоноор өгөх /видео хичээл/	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн ахлах сувилагч Х.Хандсүрэн /Тэргүүлэх зэрэгтэй/
		Тариурын шахуургаар эмчилгээ хийх аргачлал, анхаарах асуудал	
Үдийн завсарлага 13:00-14:00			
7	14:00-15:00	Шинэ үеийн сувилагч нарын шинж чанарт тулгуурлан чадваржуулах нь	БНСУ-ын Ионсей их сургуулийн судлаач, сувилахуйн докторант Д.Дуламсүрэн
8	15:00-15:45	Амьсгалыг үнэлэх, амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сувилгааны албаны дарга Б.Мөнгөнчимэг /Тэргүүлэх зэрэгтэй/
9	15:45-16:30	Амьсгалын замын эмгэгтэй хүүхдэд үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн ахлах сувилагч Д.Энхжаргал /Тэргүүлэх зэрэгтэй/
Цайны завсарлага			
10	16:40-17:15	Ярилцлага (2022 онд Сувилахуйн тусламж үйлчилгээнд хэрэгжүүлэх ажил)	ЭМГ-ын мэргэжилтэн Д.Отгонсүрэн /СУ-ны магистр, Зөвлөх зэрэгтэй/
11	17:15-18:00	Коронавируст халдварын үед ажиллах сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ёс зүй	ЭМГ-ын дарга С.Нарантуяа

12	18:00-18:30	Дотоод ажил нийгэмлэгийн мэргэжлийн зэргийн хүлээж авах/	/Тайлан, татвар, материал	ЭМГ-ын мэргэжилтэн Д.Отгонсүрэн /СУ-ны магистр, Зөвлөх зэрэгтэй/
----	-------------	---	---------------------------------	--

**“ЗААВАЛ ХИЙХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХАМРАЛТ”
СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ХӨТӨЛБӨР**

№	Цаг	Хичээлийн сэдэв	Хариуцах мэргэжилтэн
Сургалт “Цоожэд” өрхийн Эрүүл мэндийн төвийн сургалтын танхим болно. Дархлаажуулалтын сувилагч нар оролцоно.			
1	09:00-09:30	Сургалтын нээлт (ЭМГ-ын сургалтын танхимд)	ЭМГ-ын дарга С.Нарантуяа
2	09:30-10:30	Заавал хийх дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, мэдээ мэдээлэлд дүгнэлт хийх	НЭМХ-ийн дарга Д.Нарантуяа
3	10:30-11:15	Заавал хийх дархлаажуулалтын хорогдлын индекс тооцох арга аргачлал	ЭМГ-ын мэргэжилтэн Д.Лхагвадолгор
Цайны завсарлага			
4	11:30-12:00	Туберкулины сорил тавих арга зүй	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сүрьеэгийн тасгийн ахлах сувилагч С.Ганцэцэг
5	12:00-13:00	Цэрний сорьц авах, тээвэрлэх	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сүрьеэгийн тасгийн их эмч О.Оюунтөгс
Үдийн завсарлага 13:00-14:00			
6	14:00-16:00	“Туберкулины сорил хэмжих арга” дадлага ажил	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сүрьеэгийн тасгийн ахлах сувилагч С.Ганцэцэг
Цайны завсарлага			
7	16:15-16:45	Ярилцлага	Зохион байгуулагчид
8	17:15-18:00	Коронавируст халдварын үед ажиллах сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ёс зүй (ЭМГ-ын сургалтын танхимд)	ЭМГ-ын дарга С.Нарантуяа

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
01 дугаар сарын 19 ны өдрийн 0/02 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
Цайны зардал				
1	Бургер	36	4500.00	162000.00
2	Кофе	36	500.00	18000.00
3	Печень	36	2000.00	72000.00
4	Ундаа	36	2000.00	72000.00
5	Хоол	40	12000.00	480000.00
6	Нэг удаагийн аяга	2 боодол	6000.00	12000.00
7	Нэг удаагийн халбага	1 боодол	4000.00	4000.00
8	Сальфетик /хуурай/	4	1500.00	6000.00
Бичиг хэрэг				
9	Тунгалаг шугам	16	1500.00	24000.00
10	Бичгийн цаас	1 боодол	20000.00	20000.00
				Сургалтын бүгд зардал 870000.00 төгрөг